

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## **Агуулга**

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайланг ийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин гүйцэтгэлийн талаар тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	14
4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

ҮАГ	Үндэсний аудитын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
"ЦАГААН ШОНХОР" ТӨҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Б.АРИУНЗАЯА ТАНАА

2020.03.13 № 06/832  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн Ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Цагдаагийн ерөнхий газрын Цагаан шонхор ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга Б.Ариунзаяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шатахууны тооцоо, санхүүгийн тайлангийн хуулийн хугацаа хоцроосон, зардлын ангилал, бараа материал, анхан шатны баримт бүрдэл, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-өөс 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь удирдах ажилтны манлайлал, ажилтан ажилчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод шударга шуурхай хуульч ажиллагааг хэвшүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хуулийн этгээдийн алба хаагчдад зориулалтын стандарт бүхий хувцас хэрэглэлээр хангаж үйлчлэх;
- Захиалагчдын захиалгын дагуу чанар стандартын шаардлага хангасан хувцас, хэрэглэлийг оёж, бэлтгэн нийлүүлэх;
- Өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах нэрийн дэлгүүрийг зохих журмын дагуу ажиллуулах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн / шинэчилсэн найруулга/

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Инфосистем ХХК-ийн “Макс” программ хангамж ашигладаг байна.

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 218.9 сая төгрөгөөс тооцон 4.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас 2.0 хувиар тооцон 14.9 сая төгрөгөөр тогтоолоо.

**2.8. Санхүүгийн тайланг ийн үзүүлэлтүүд**

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 365.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.3	71.4	65.1
Авлага	0.1	207.0	206.9
Бараа материал	80.2	213.6	133.4
Үндсэн хөрөнгө	425.0	385.0	(40.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>511.6</b>	<b>877.0</b>	<b>365.4</b>
Өр төлбөр	40.5	16.4	(24.1)
Урьдчилж орсон орлого		309.6	309.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	471.1	551.0	79.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>511.6</b>	<b>877.0</b>	<b>365.4</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, урьдчилж орсон орлогын дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 65.1 сая төгрөгөөр өссөн нь 2019 оны 12 дугаар сарын 29-нд Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанаас гэрээт ажлын урьдчилгаа санхүүжилт олгосноос шалтгаалжээ.

Тендерийн урьдчилгаа төлбөрийн баталгаанд 206.9 сая төгрөг байршуулсан нь авлагаар бүртгэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133.5 сая төгрөгөөр өссөн нь Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү Аж ахуйн албаны захиалгатай тайлант онд дуусаагүй 2 гэрээт ажлын түүхий эд материалын үлдэгдэлтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үед 42,7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-5/1233 тоот тогтоолоор 13 нэр төрлийн 7.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна. Тайлант онд 3.3 сая төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан.

## **Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

Өр төлбөр дансны үлдэгдэл 24.1 сая төгрөгөөр буурсан нь урд оны зөвлөмжийг хэрэгжүүлэн бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг, татварын өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалжээ. Өр төлбөрийн үлдэгдэлд 16.3 сая төгрөгийн ААНОАТ, ХАОАТ-ын өр төлбөр байна.

Урьдчилж орсон орлогын дансны үлдэгдэл 309.6 сая төгрөгөөр өссөн нь Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү Аж ахуйн албанаас дүрэмт хувцасны захиалгын 2 гэрээт ажлын урьдчилгаа олгосонтой холбоотой.

Төрийн өмчийн данс 79.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлагдсан ашиг 56.7 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 24.4 сая төгрөг зэргээр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд ТӨБЗГ-т 2018 оны ногдол ашиг 1.2 сая төгрөгийг төлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 24.4 сая төгрөгийн бичилт нь удаан жил болсон, эрэн сурвалжилсан боловч олдоогүй өр төлбөрийг бүртгэсэнтэй холбоотой байна.

### **2.9. Зорилтот түвшин гүйцэтгэлийн талаар тодруулга**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 586 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ нь тайлант онд 812.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 755.5 сая төгрөгийг зарцуулж, 56.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Орлого өмнөх оныхоос 95.5 сая төгрөгөөр, зардал 49.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд харилцагч байгууллагын тоо нэмэгдсэн, үндсэн захиалагч Цагдаагийн ерөнхий газрын захиалгын тоо ширхэг өссөнөөс орлого, зардал өссөн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 715.8 сая төгрөг буюу төлөвлөгөөнөөс 13.5 хувиар давуулан биелүүлсэн бол 696.0 сая төгрөгийн зардлын төлөвлөгөө баталснаас 755.5 сая төгрөг зарцуулж зардлыг 8.5 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

### **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 335.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 326.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 8.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 9.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны бараа борлуулсан, үйлчилгээний орлогыг 154.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан, үндсэн үйл ажиллагааны 16.8 сая төгрөгийн зардлыг үндсэн бус үйл ажиллагааны зардалд буруу ангилан бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийн дутуу тооцсон 0.1 сая төгрөгийг залруулан бүртгэсэн, ноогдол ашгийн зардал 1.1 сая төгрөгийг бусад зардалд бүртгэсэн, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 153.9 сая төгрөгийн үйлдвэрлэлийн ажиллагсдын цалин хөлсийг оруулж тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна. Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 249 тоот тушаалын 6-д “Гарсан зардал болон олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зардлыг



## Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

хүлээн зөвшөөрнө. Орлого, зардал уялдана гэдэг нэг ажил гүйлгээ эсвэл бусад үйл явдлын шууд ба хамтарсан үр дүн болж, орлого ба зардлыг нэгэн зэрэг буюу нэгтгэн хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.”, 2.2.5-д “Аж ахуйн нэгж хөрөнгийн өгөөжийг хэрхэн хүртэхийг харгалзаж үзсэний үндсэн дээр үндсэн хөрөнгийг ашиглах зохистой хугацааг тогтоож, түүнд элэгдэл тооцох тохиромжтой аргыг сонгон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган тууштай мөрдөнө” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Тайлант хугацаанд шатах, тослох материалын нярвын тайланг бэлтгэхдээ авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй, өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй 1.0 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан " Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 4 хоног хоцроосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т зааснаар “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 8.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Аудитаар горим сорил хэрэгжүүлээгүй, материаллаг шинжтэй, дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээлэл байршуулахаас 106 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 15 мэдээллийг байршуулаагүй байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжөөр 1.9 сая төгрөгийн шатахууныг тооцоо бодолгүй шууд зардалд бүртгэсэн 1 албан шаардлага хүргүүлсэнг тайлант онд хэрэгжүүлээгүй байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс, хувь хүн иргэнээс бараа материал худалдан авахдаа хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, олон жил болсон өр төлбөрийг барагдуулаагүй 2 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

Санхүүгийн тайланд бидний илрүүлэлтээр залруулагдаагүй 9.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 14.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Цагдаагийн Ерөнхий газрын Цагаан шонхор ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС , СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Ажилтнуудад олгосон дараа тайлангийн тооцоо 4.7 сая төгрөгийг шууд зардалд бүртгэсэн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 12 өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөгдөх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.2-т “Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Анхан шатны баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавигдах хяналтын тогтолцоо алдагдах;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Ажилтнуудад тооцоо үүсгэж, гүйцэтгэлийг хянан зөрүүг тооцож байх, анхан шатны баримтыг үндэслэн зардалд бүртгэх;

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Ажиллагсдын тооцоог холбогдох дүрэм журмын дагуу бодож, хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Бараа материалын тайланд зарлагын баримт, шаардах хуудас зэрэг санхүүгийн анхан шатны баримт, бүртгэлийг бүрэн гүйцэд хөтлөөгүй 1.7 сая, бэлэн мөнгөний зарлагын баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ бүртгэсэн 1.6 сая төгрөг нийт 3.3 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан " Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл,

## **Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Анхан шатны бүрдэл дутуу, хангаагүй баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтаар холбогдох ажилтнаар гарын зурж баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээ хийгүй байх, холбогдох хууль, заавар, журмыг мөрдөж ажиллах.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Хүлээн авсан хүлээлгэн өгсөн ажилтнаар баталгаажуулах, татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгж, хувь хүнээс худалдан авалт хийн ажиллана.

## **3.3 Балансын данстай холбоотой асуудал**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Цагдаагийн Ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээлэл байршуулахаас 106 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 15 мэдээллийг огт байршуулаагүй зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Мэдээллийн ил тод байдал алдагдах эрсдэлтэй.

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан, хэрэглэгчдийг мэдээллээр ханган, хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан хуулийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,272,666.34	71,391,847.44
1.1.2	Дансны авлага		206,970,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	105,036.42	
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	80,159,877.38	213,622,493.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгө )		
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>86,537,580.14</b>	<b>491,984,340.84</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	346,710,807.27	307,306,505.95
1.2.2	Биет бус хөрөнгө	78,240,106.67	77,621,356.67
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>424,950,913.94</b>	<b>384,927,862.62</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>511,488,494.08</b>	<b>876,912,203.46</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	30,408,883.00	157,080.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	10,050,561.78	16,220,678.60
2.1.1.4	НДШ- ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн  
тайлангийн аудит**

2.1.1.8	Урьдчилж орсон орлого		309,570,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө )-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>40,459,444.78</b>	<b>325,947,758.60</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>40,459,444.78</b>	<b>325,947,758.60</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: -төрийн	59,469,098.00	59,469,098.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	201,226,713.00	201,226,713.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	92,199,766.00	92,199,766.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	118,133,472.30	198,068,867.87
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>471,029,049.30</b>	<b>550,964,444.87</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>511,488,494.08</b>	<b>876,912,203.46</b>

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>704,239,550.00</b>	<b>810,527,500.00</b>
2	Борлуулалтын өртөг	194,289,308.80	455,097,436.40
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>509,950,241.20</b>	<b>355,430,063.60</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,131,303.55	754,521.20
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	11,218,112.51	839,940.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,916,000.00	695,400.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	490,917,025.88	281,500,042.65
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	18,842,441.21	10,639,060.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11,118.19	4,653.46
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>10,635,308.36</b>	<b>64,194,675.61</b>
19	Орлогын татварын зардал	2,946,662.89	7,482,908.23
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>7,688,645.47</b>	<b>56,711,767.39</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>7,688,645.47</b>	<b>56,711,767.39</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>7,688,645.47</b>	<b>56,711,767.39</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>7,688,645.47</b>	<b>56,711,767.39</b>

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	59,469,098			109,154,324.83	168,623,422.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		201,226,713.00	92,199,766.00	1,290,502.00	294,716,981.00
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>59,469,098</b>	<b>201,226,713 .00</b>	<b>92,199,766.00</b>	<b>110,444,826.83</b>	<b>463,340,403.83</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				7,688,645.47	7,688,645.47
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>59,469,098</b>	<b>201,226,713.00</b>	<b>92,199,766.00</b>	<b>118,133,472.30</b>	<b>471,029,049.30</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				24,376,925.00	24,376,925.00
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>					-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				56,711,767.39	56,711,767.39
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт					-
15	Зарласан ногдол ашиг				(1,153,296.82)	(1,153,296.82)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>59,469,098</b>	<b>201,226,713.00</b>	<b>92,199,766.00</b>	<b>198,068,867.87</b>	<b>550,964,444.87</b>



**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>592,473,913.00</b>	<b>1,219,445,836.20</b>
1.1.1	Бараа борлуулсны, үйлчилгээ үзүүлсний орлого	579,125,613.00	809,627,000.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,302,749.00	165,410.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	10,045,551.00	409,653,426.20
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>695,054,759.79</b>	<b>1,150,629,632.94</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	301,356,291.00	231,923,700.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	69,656,860.46	60,603,171.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	225,977,748.57	304,381,995.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,241,058.67	10,236,062.52
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,031,478.00	10,511,410.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	29,867,887.70	20,966,358.66
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	49,923,435.39	512,006,934.51
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(102,580,846.79)</b>	<b>68,816,203.26</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,131,303.55</b>	<b>754,521.20</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүний орлого	1,131,303.55	754,521.20
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,500,000.00</b>	<b>3,302,900.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,500,000.00	3,302,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(4,368,696.45)</b>	<b>(2,548,378.80)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>30,700,000.00</b>	<b>55,670,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	30,700,000.00	55,670,000.00

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>30,700,000.00</b>	<b>56,823,296.82</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	30,700,000.00	55,670,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		1,153,296.82
3.2.5			
<b>3.3</b>	<b>санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(1,153,296.82)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>11,118.19</b>	<b>4,653.46</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(106,938,42.05)</b>	<b>65,119,181.10</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>113,211,091.39</b>	<b>6,272,666.34</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,272,666.34</b>	<b>71,391,847.44</b>

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**4.5 . Аудит хийсэн зорилтот түвшин**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b><u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</u></b>		
	<b>б/ Үнийн дүнгээр</b>	<b>715,836,400.00</b>	<b>812,126,614.66</b>
2	<b>Нийт орлого</b>	<b>715,836,400.00</b>	<b>812,126,614.66</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	715,836,400.00	812,126,614.66
3	<b>Нийт зардал</b>	<b>696,093,000.00</b>	<b>747,931,939.05</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	155,642,900.00	83,711,511.50
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>19,743,400.00</b>	<b>64,194,675.61</b>
5	<b>Цэвэр ашиг / алдагдал /</b>	<b>17,769,100.00</b>	<b>56,711,767.39</b>
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.97	
7	Нийт авлага		206,970,000.00
8	Нийт өглөг		16,377,758.60
	Үүнээс:Богино хугацаат өр төлбөр		
9	Хөрөнгө оруулалт	45,400,000.00	
10	Ногдол ашиг	1,604,200.00	3,711,650.89
11	Нийт ажиллагсадын тоо	74.00	71.00
12	Нийт цалингийн сан	386,871,500.00	279,174,317.29
13	Нэг ажилтны дундаж цалин	435,700.00	327,669.39

**Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит**

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2019</b>	Аудитын нэр: <b>Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2020/58/СТА-ТӨҮГ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “ЦАГААН ШОНХОР” ТӨҮГ</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны 142 мэдээлэл байршуулахаас 106 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 15 мэдээллийг огт байршуулаагүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ариунзаяа, Ц.Цэнгэлмаа
2	2019 оны санхүүгийн тайланг 4 хоногоор хоцроон тушаасан		Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Цэнгэлмаа
3	Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг бүртгэхдээ 1,648.7 мянган төгрөг, бараа материалын зарлагын падааны гарын үсэг дутуу 1,735.5 мянган төгрөг нийт 3,384.7 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу гүйлгээ хийж, бүртгэл хөтөлсөн байна.	3,384.7	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Ариунзаяа, Ц.Цэнгэлмаа
4	Дараа тайлангийн тооцоогоор 4,681.7 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн.	4,681.7	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Ариунзаяа, Ц.Цэнгэлмаа
5	Шатахууны тооцоог бодохдоо хэтрэлт, хэмнэлт тооцоогүй, замын хуудсыг гарын үсгээр баталгаажуулаагүй.	1,041.3	Төлбөрийн акт тогтоох	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Ариунзаяа, Ц.Цэнгэлмаа
<b>Нийт дүн</b>		<b>9,107.7</b>			



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/68

Улаанбаатар хот

САА - 2020/118/САА - ТӨҮГ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн ЦЕГ-ын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд шатах, тослох материалын нярвын тайланг бэлтгэхдээ авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй, өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй 1,041,316.0 төгрөгийн зөрчил гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодолгүй зарцуулсан 1,041,316.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэн төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд 2020 оны 06 дугаар сарын 01-ний дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлэхийг ЦЕГ-ын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын захирал Б.Ариунзаяа, нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт хариуцуулав.

## ТӨЛБӨРИЙН АКТЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-НИЙ  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

О.БАЯРМАА

Ч.ОЮУН

ЗӨВШӨӨРСӨН:

ЦЕГ-ЫН "ЦАГААН ШОНХОР" ТӨҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Б.АРИУНЗАЯА

НЯГТЛАН БОДОГЧ

Ц.ЦЭНГЭЛМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь эхлэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie\_Kheree\Akt\2020\03\20\SAG1 Docx

001090178



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02 № 02/150

Улаанбаатар хот

САГ-2020/118/СТА-ТӨҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн ЦЕГ-ын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 4 хоног хоцроосон зөрчил гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т зааснаар “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуулийн цаглабарт хугацаанд хоцроохгүй, ирүүлж байх, цаашид давтан гаргахгүй байх.
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг ЦЕГ-ын “Цагаан шонхор” ТӨҮГ-ын дарга Б.Ариунзаяа, нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-НЫ  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

О.БАЯРМАА

Ч.ОЮУН

ЗӨВШӨӨРСӨН:

ЦЕГ-ЫН “ЦАГААН ШОНХОР” ТӨҮГ-ЫН  
ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.АРИУНЗАЯА

Ц.ЦЭНГЭЛМАА

Акт, албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь залах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



